

## ШИНЖЭЭЧ СОНГОН ШАЛГАРУУЛАХ УРИЛГА

2022.11.09

Зуунмод

1. Төв аймаг дахь Төрийн аудитын газар нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1, 8.9.8, Төрийн аудитын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/82 дугаар тушаалаар батлагдсан “Шинжээч сонгон шалгаруулах, гэрээ байгуулах, дүгнэх, гүйцэтгэсэн ажлын чанарыг хянах журам”-ыг тус тус үндэслэн “Зарим төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит байгууллагуудын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийх санхүүгийн тайлангийн аудитыг (багц 3, багц 4) гүйцэтгэх шинжээч сонгон шалгаруулна.

Иймд дэлгэрэнгүй жагсаалтад орох хүсэлтэй аудитын хуулийн этгээдийг саналаа ирүүлэхийг урьж байна.

Зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулах багцын жагсаалт, ажлын даалгаврыг үндэслэн саналын жишиг баримт бичгийг маягтын дагуу бүрдүүлж ирүүлнэ. Үүнд:

Бүлэг 1. Урилга

Бүлэг 2. Ажлын даалгавар

Бүлэг 3. Саналын жишиг бичиг баримт

Бүлэг 4. Гэрээний ерөнхий болон тусгай нөхцөл

2. Саналын жишиг баримт бичгийг Төв аймаг дахь Төрийн аудитын газраас цахимаар болон цаасаар авна уу.

3. Нэмэлт мэдээллийг авах хүсэлтийг санал ирүүлэх хугацаанаас ажлын 2 хоногийн өмнө албан бичгээр ирүүлнэ.

4. Саналаа битүүмжлэн дор дурдсан хаягаар 2022 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн 15 цаг 00 минутын дотор цаасаар болон цахим хэлбэр ([tuv@audit.gov.mn](mailto:tuv@audit.gov.mn))-ээр хаягт ирүүлнэ үү.

5. Хугацаа хоцроосон мэдүүлгийг хүлээн авахгүй болно.

Хаяг: Төв аймаг, Зуунмод сум, Төр захиргааны 2-р байр, 102 тоот  
Холбоо барих албан тушаалтны нэр: Аудитын менежер О.Амаржаргал  
Утас: 88039862

